

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН 2018 ОНЫ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

## Агуулга

1.	Аудитын гэрчилгээ .....	2
2.	Аудитын тайлан .....	3
2.1.	Оршил .....	4
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	4
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	4
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	5
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	6
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	6
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	6
2.8.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .....	7
2.8.1.	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	7
2.9.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	8
2.10.	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	8
2.11.	Шилэн дансны мэдээлэл.....	8
2.12.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга .....	8
2.13.	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл .....	9
3.	Менежментийн захидал.....	10
4.	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	13
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	13
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	15
4.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	17
4.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	19
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	20
4.6	Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	22
5.	Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	23

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:62-26-32-30  
E-mail: info@audit.gov.mn

2019.02.25 № 06/270  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Барилгын политехникийн коллежийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Барилгын политехникийн коллежийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Барилгын политехникийн коллежийн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

## Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## **2. Аудитын тайлан**

### **2.1. Оршил**

Барилгын политехникийн коллежийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг тус коллежийн захирал Г.Нямдулам Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

### **2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Барилгын политехникийн коллежийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Барилгын политехникийн коллежийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 9 дүгээр сарын 20-ноос 2019 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2018 оны 02 дугаар сарын 21-ний өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн “Ихмонгол хөлөг Аудит” ХХК хэрэгжүүлэв.

Барилгын политехникийн коллеж 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг “Ихмонгол хөлөг Аудит” ХХК-д 2019 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 1/08 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

#### **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Барилгын политехникийн коллежийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Барилгын политехникийн коллеж нь Олон улсын жишигт нийцсэн барилгын мэргэжилтэн бэлтгэх, сургалт үйлдвэрлэлийн тэргүүлэх сургууль байх гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдтай байгуулсан үр дүнгийн гэрээгээр Барилгын политехникийн коллежийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Сургуулийн хөгжлийн төлөвлөлт, удирдлага зохион байгуулалтыг боловсронгуй болгох
- Нийгмийн түншлэлийг хөгжүүлэх
- Багш, хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх
- Багшлах боловсон хүчний чадавхийг үе шаттайгаар дээшлүүлэх
- Эрдэм шинжилгээ, судалгаа, туршилтын ажлыг гүйцэтгэх
- Санхүү, сургалтын орчинг сайжруулах

Барилгын политехникийн коллежийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Барилгын политехникийн коллежийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль

- Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

## **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд байгууллагын онцлог, шинээр батлагдсан хууль, бодлого, журамд нийцүүлэн зарим өөрчлөлтийг оруулах шаардлагатай байна.

Барилгын политехникийн коллежийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд Шаардлагагүй буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Барилгын политехникийн коллеж нь санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Acolous 3.0” програм хангамж ашигладаг байна.

Барилгын политехникийн коллежийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

## **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитын явцад Барилгын политехникийн коллежийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 15 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 15 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

## **2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1 хувиар сонгов.

2018 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь Материаллаг байдлын суурийг нийт хөрөнгө, цэвэр хөрөнгө,

нийт орлогын дүнгээс тооцоход өндөр байгаа тул нийт зардлын дүнгээс тооцох нь зүйтэй гэж үзсэнтэй холбоотой юм.

Барилгын политехникийн коллежийн 2018 оны 2018 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2,666,236.9 мянган төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 26,662.37 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тооцсон нь материаллаг алдаа илүү давах магадлал бага гэж үзсэнтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг B201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг B401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

## 2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 7 чиглэлээр аудитын 18 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 11 асуудлыг алдаа, зөрчилтөйд тооцож, 3 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 4 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг B30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг B501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй  
асуудлыг ангилсан байдал

№	Шийдэл	Тоо	Дүн	-Мянган төгрөгөөр
				Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	5	57,734.4	
2	Төлбөрийн акт тогтоосон	1	24,000.0	
3	Албан шаардлага өгсөн	5	137,019.4	
	Дүн	11	218,753.9	

### 2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

Бараа бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээний дүнгээс 384.3 мянган төгрөгөөр илүү шууд худалдан авалт хийсэн.

Шийдвэрлэсэн: Албан шаардлага өгөх

Тайлант онд дотуур байр түрээслүүлсний 80,000.0 мянган төгрөгийн орлогын 30 хувь 24,000.0 төгрөгийг төсөвт төвлөрүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн: Төлбөрийн акт тогтоох

Хөдөлгүүрийн цилиндрийн багтаамж нь 2500 см<sup>3</sup>-ээс дээш, туулах чадвар өндөртэй 89,112.2 мянган төгрөгийн үлдэх өртөгтэй ланд-200 суудлын автомашиныг ашиглаж, 20,376.0 мянган төгрөгийн засварын зардал гаргаж, төсвийг үр ашиггүй зарцуулсан байна.

Шийдвэрлэсэн: Албан шаардлага өгөх

Түрээсийн орлогын төлбөр тооцоог сар бүр гэрээний дагуу бүртгэж тайлагнадаггүйгээс 11,305.0 мянган төгрөгийн орлогыг түрээслэгчтэй байгуулсан гэрээгүйгээр бүртгэсэн байна.

Шийдвэрлэсэн: Албан шаардлага өгөх

Тайлант хугацаанд нийт 74 удаагийн 15,841.9 мянган төгрөгийн бараа материалыг орлогод бүртгэхдээ И баримтыг хавсаргаагүй байна.

Шийдвэрлэсэн: Албан шаардлага өгөх

2018 оны жилийн эцэст хөрөнгийн тооллого хийсэн боловч тооцоог бодоогүй байна.

Шийдвэрлэсэн: Албан шаардлага өгөх

## **2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Дотуур байрны түрээсийн орлогын 30 хувийг Засгийн газрын 2001 оны 134 дүгээр тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 102 дугаар тогтоолуудын холбогдох заалтын дагуу улсын төсөвт төвлөрүүлж байгаа эсэхийг дараагийн аудитаар дахин үзэх шаардлагатай гэж үзсэн.

## **2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Барилгын политехникийн коллеж чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 2,271,411.7 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 2,267,772.8 мянган төгрөг буюу 99.8 хувьтай байна.

## **2.11. Шилэн дансны мэдээлэл**

Барилгын политехникийн коллеж Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

## **2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 100 хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

### **2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Барилгын политехникийн коллежийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Барилгын политехникийн коллежийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

### **3. Менежментийн захидал**

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Барилгын политехникийн коллежийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### **1. Зардлын талаар**

##### **1.1. Илрүүлэлт:**

Дотуур байрны хүүхдийн хоолны төлбөр болох 220.3 мянган төгрөгийг хог хаягдлын зардлаас зарцуулсан байна. Энэ нь Сангийн сайдын 2015 оны "төсвийн ангилал, шинэчлэн батлан тухай" 7 дугаар тушаал, санхүүгийн тайлагналын үнэн зөв байдал, эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлүүдтэй тус тус нийцэхгүй байна.

##### **1.2. Эрсдэл:**

Зардлын ангилал зөрүүлж зарцуулах

##### **1.3. Өгсөн зөвлөмж:**

Холбогдох хууль, тогтоомжийг мөрдөж ажиллах

##### **1.4. Байгууллагын өгсөн хариу:**

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

## 2. Авлагын, өр төлбөрийн талаар

### 2.1 Илрүүлэлт:

Авлагын үлдэгдэл 42,645.4 мянган төгрөг буюу оны эхнээс 13,290.1 мянган төгрөгөөр, өр төлбөр 39,672.2 мянган төгрөг буюу оны эхнээс 950.7 мянган төгрөгөөр тус тус өссөн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэж заасныг, санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг батламж мэдэгдлүүдтэй тус тус нийцэхгүй байна.

### 2.2 Эрсдэл:

Авлага, өр төлбөрийг бууруулахгүй ажиллах

### 2.3 Өгсөн зөвлөмж:

Авлага, өр төлбөрийг бууруулж ажиллах

### 2.4 Байгууллагын өгсөн хариу:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

## 3. Бараа материалын талаар

### 3.1. Илрүүлэлт:

Байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн 2018 оны 06/18 дугаартай дүгнэлтээр 42 нэр төрлийн 13,783.6 мянган төгрөгийн бараа материалыг бүртгэлээс хасах шийдвэр гаргасан боловч борлуулах, устгах тухай заагаагүй байна. Энэ нь санхүүгийн тайлагналын үнэн зөв байдал, эрх ба үүрэг гэх батламж мэдэгдлүүдтэй нийцэхгүй байна.

### 3.2. Эрсдэл:

Шийдвэрлээгүй эргэлтийн хөрөнгийг шамшигдуулах

### 3.3. Өгсөн зөвлөмж:

Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хурлын тэмдэглэлд шийдвэрийг тодорхой тусгах.

### 3.4. Байгууллагын өгсөн хариу:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

## 4. Бараа материалын талаар

### 4.1. Илрүүлэлт

Нийт 1,002.4 мянган төгрөгийн бараа материалыг захиалгын хуудсаар олгохдоо гарын үсгээр баталгаажуулаагүй байна. Энэ нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7.5-д "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно." гэсэн заалт, санхүүгийн тайлагналын үнэн зөв байдал, эрх ба үүрэг гэх батламж мэдэгдлүүдтэй нийцэхгүй байна.

### 4.2. Эрсдэл

Бараа материал дутагдах

### 4.3. Өгсөн зөвлөмж

Холбогдох хууль, журмыг мөрдөж ажиллах

#### 4.4. Байгууллагын өгсөн хариу

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

#### 5. Нягтлан бодох бүртгэлийн талаар

##### 5.1. Илрүүлэлт

Цалин хөлсөнд илүү олгосон 24,001.0 мянган төгрөг, дутуу олгосон 4,486.4 мянган төгрөг нийт 28,487.4 мянган төгрөгийг цалингийн цэсэнд сөрөг утгатайгаар бүртгэсэн байна. Энэ нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.2-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ давхар бичилтийн аргаар хөтөлнө", 3.1.2-д "давхар бичилт" гэж ажил, гүйлгээг дансны дебет, кредитэд зэрэг бичилт хийхийг", Төсвийн тухай хуулийн 6.3.1-т "Төсвийн орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөрийн гүйлгээг бууруулах бичилт хийхгүйгээр нийт дүнгээр нь төлөвлөж, тайлагнах" гэж заасныг, санхүүгийн тайлагналын үнэн зөв байх, тайлагнал ба толилуулга батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

##### 5.2. Эрсдэл

Санхүүгийн тайлан зөрүүтэй тайлагнагдах

##### 5.3. Өгсөн зөвлөмж

Холбогдох хууль тогтоомжийг мөрдөж ажиллах

#### 5.4. Байгууллагын өгсөн хариу

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

##### Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	321,749,789.60	379,546,698.82
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	21,000.00	20,200.00
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	21,000.00	20,200.00
31110	Төгрөг	21,000.00	20,200.00
32	БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	-	-
33	АВЛАГА	29,355,355.00	42,645,438.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	3,300,000.00	5,920,000.00
335	Бусад авлага	26,055,355.00	36,725,438.00
3351	Байгууллагаас авах авлага	1,129,935.00	2,192,260.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	24,925,420.00	34,533,178.00
34	УРЬДЧИЛГАА	71,400.00	954,222.00
34600	Урьдчилж гарсан зардал	71,400.00	3,000.00
3471	Урьдчилгаа тооцоо	-	951,222.00
34713	Цалингийн урьдчилгаа	-	951,222.00
35	БАРАА МАТЕРИАЛ	292,302,034.60	335,926,838.82
351	Түүхий эд материал	51,825,655.25	53,312,023.04
35110	Тусгай зориулалттай материал	50,840,573.25	51,769,324.32
35130	Эм боох материал	985,082.00	1,542,698.72
35200	Дуусаагүй үйлдвэрлэл	-	18,842,522.24
35300	Бэлэн бүтээгдэхүүн	8,106,575.00	7,311,575.00
354	Хангамжийн материал	232,369,804.35	256,460,718.54
35410	Бичиг хэргийн материал	14,688,887.41	16,463,699.41
35420	Аж ахуйн материал	8,061,150.00	10,999,100.00
35430	Сэлбэг хэрэгсэл	3,502,000.00	4,523,600.00
35440	Түлш, шатах тослох материал	470,000.00	200,000.00
35450	Барилгын засварын материал	7,335,100.00	6,679,100.00
35460	Хүнсний материал	-	700,000.00
35470	Бусад хангамжийн материал	198,312,666.94	216,895,219.13
36	НӨӨЦИЙН БАРАА	-	-
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,342,157,289.46	3,969,434,940.04
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	-	-
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,342,157,289.46	3,969,434,940.04
392	Биет хөрөнгө	2,327,200,502.86	3,566,513,684.52
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,905,802,305.00	7,059,643,870.08
39202	Хуримтлагдсан элэгдэл	-2,448,817,835.49	-4,587,870,494.10
39203	Авто-тээврийн хэрэгсэл	62,940,000.00	232,686,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-54,241,610.87	-130,399,198.07
39205	Машин тоног төхөөрөмж -компьютер	2,371,820,309.98	2,660,699,654.58
39206	Хуримтлагдсан элэгдэл	-1,897,947,910.26	-2,053,293,505.56
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	268,096,480.48	288,383,304.08
39208	Хуримтлагдсан элэгдэл	-165,776,779.75	-191,202,484.26
39216	Дуусаагүй барилга, байгууламж	13,522,650.00	13,522,650.00
39217	Ном	271,802,893.77	274,343,887.77
393	Биет бус хөрөнгө	14,956,786.60	402,921,255.52
39301	Програм хангамж	60,821,968.87	64,041,234.87
39302	Хуримтлагдсан элэгдэл	-45,865,182.27	-52,084,319.35
39303	Бусад биет бус хөрөнгө	-	390,964,340.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,663,907,079.06	4,348,981,638.87

**Барилгын политехникийн коллежийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>38,721,544.59</u>	<u>39,672,209.53</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	29,005,933.89	30,626,637.53
413	Өглөг	5,700,933.89	8,595,637.53
4136	Бусад өглөг	5,700,933.89	8,232,193.00
41361	Байгууллагад төлөх өглөг	2,400,933.89	1,266,610.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	3,300,000.00	6,965,583.00
414	Урьдчилж орсон орлого	23,305,000.00	22,031,000.00
41440	Бусад урьдчилж орсон орлого	23,305,000.00	22,031,000.00
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	9,715,610.70	9,045,572.00
422	Урт хугацаат зээл	9,715,610.70	9,045,572.00
4221	Төгрөг	9,715,610.70	9,045,572.00
42214	Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн зээл	9,715,610.70	9,045,572.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>2,625,185,534.47</u>	<u>4,309,309,429.33</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	2,625,185,534.47	4,309,309,429.33
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	3,631,698,814.29	4,022,413,154.29
51101	Өмч: - төрийн	3,631,698,814.29	4,022,413,154.29
512	Хуримтлагдсан үр дүн	-1,376,534,618.13	-1,071,084,938.72
51210	Өмнөх үеийн үр дүн	-1,376,534,618.13	-1,375,594,340.03
51220	Тайлант үеийн үр дүн	-	304,509,401.31
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	370,021,338.31	1,357,981,213.76
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>2,663,907,079.06</u>	<u>4,348,981,638.86</u>

## Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
			/төгрөгөөр/
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН -I	2,502,412,875.09	2,970,746,361.26
11	ТАТВАРЫН ОРЛОГО	-	-
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	440,185,475.09	664,500,310.26
120	Нийтлэг татварын бус орлого	440,185,475.09	664,500,310.26
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	440,185,475.09	664,500,310.26
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	119,520,270.00	107,717,100.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	103,544,242.33	110,335,679.68
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	217,120,962.76	446,447,530.58
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,062,227,400.00	2,306,246,051.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,052,064,900.00	2,274,242,548.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,052,064,900.00	2,076,701,700.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	00.00	197,540,848.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	10,162,500.00	32,003,503.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	10,162,500.00	19,261,688.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	12,741,815.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,728,591,103.27	2,563,182,636.55
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,728,591,103.27	2,563,182,636.55
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,510,929,093.47	2,426,726,439.74
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,394,107,541.34	1,470,971,040.00
210101	Үндсэн цалин	1,060,425,631.79	1,044,103,429.00
210102	Нэмэгдэл	170,325,866.55	293,946,359.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	163,356,043.00	132,921,252.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	152,776,531.41	175,516,165.85
210201	Тэтгэврийн даатгал	98,381,545.28	118,095,012.19
210202	Тэтгэмжийн даатгал	13,860,028.13	14,595,835.81
210203	ҮОМШӨ-ний даатгал	11,217,781.00	11,772,285.85
210204	Ажилгүйдлийн даатгал	2,665,198.00	2,742,024.00
210205	Эрүүл мэндийн даатгал	26,651,979.00	28,311,008.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	136,984,364.84	116,007,361.30
210301	Гэрэл, цахилгаан	47,711,469.37	43,918,389.90
210302	Түлш, халаалт	68,877,940.12	50,545,322.99
210303	Цэвэр, бохир ус	20,394,955.35	21,543,648.41
2104	Хангамж, бараа материалын зардал	67,281,249.04	43,994,964.74
210401	Бичиг хэрэг	20,186,612.67	15,876,343.00
210402	Тээвэр, шатахуун	5,101,760.00	5,531,101.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,936,502.12	9,163,157.74
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,324,000.00	2,364,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	19,644,409.25	5,993,953.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	12,087,965.00	5,065,810.00
2105	Нормативт зардал	67,884,942.00	57,128,118.40
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,007,022.00	1,451,383.40
210502	Хоол, хүнс	54,063,900.00	51,784,235.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	12,814,020.00	3,892,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	73,636,890.40	18,347,912.80
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	29,690,200.00	6,435,860.00
210604	Урсгал засвар	43,946,690.40	11,912,052.80

**Барилгын политехникийн коллежийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

2107	Томилолт, зочны зардал	4,155,681.00	2,630,008.00
210702	Дотоод албан томилолт	4,155,681.00	2,180,108.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	-	449,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	40,958,789.00	18,570,813.76
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	33,600,000.00	5,724,073.76
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	4,500,000.00	11,250,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	346,100.00	00.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	237,200.00	287,010.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	61,000.00	108,200.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	536,377.00	1,022,200.00
210807	Газрын төлбөр	653,812.00	26,400.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	-	5,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,024,300.00	147,930.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	573,143,104.44	523,560,054.89
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	178,851,375.40	218,214,391.54
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	394,291,729.04	305,345,663.35
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	217,662,009.80	136,456,196.81
2132	Бусад урсгал шилжүүлэг	211,961,800.00	124,627,474.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	114,026,300.00	62,678,770.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	53,744,000.00	61,948,704.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	44,191,500.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,700,209.80	11,828,722.81
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,700,209.80	11,828,722.81
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН -3=-1--2	-226,178,228.18	407,563,724.71
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	103,054,323.40
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	6,751,889.20
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	-	96,302,434.20
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН -4=-145-225	-	-103,054,323.40
5	НИЙТ ҮР ДҮН -5=-3+-4	-226,178,228.18	304,509,401.31

## Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл /төгрөгөөр/
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН -1	2,286,399,986.33	2,515,062,406.00
11	ТАТВАРЫН ОРЛОГО	-	-
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	224,172,586.33	208,816,355.00
120	Нийтлэг татварын бус орлого	224,172,586.33	208,816,355.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	224,172,586.33	208,816,355.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	112,284,250.00	92,277,020.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	111,888,336.33	116,539,335.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,062,227,400.00	2,306,246,051.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,052,064,900.00	2,274,242,548.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,052,064,900.00	2,076,701,700.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	-	197,540,848.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	10,162,500.00	32,003,503.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	10,162,500.00	19,261,688.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	12,741,815.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН -2	2,269,605,861.34	2,241,657,269.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,269,605,861.34	2,241,657,269.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,052,335,353.54	2,099,281,072.19
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,432,659,978.54	1,454,884,900.00
210101	Үндсэн цалин	1,058,574,278.54	1,080,799,200.00
210102	Нэмэгдэл	295,133,200.00	295,133,200.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	78,952,500.00	78,952,500.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	156,873,700.00	173,911,200.00
210201	Тэтгэврийн даатгал	99,828,800.00	115,940,800.00
210202	Тэтгэмжийн даатгал	14,261,200.00	14,492,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	11,409,000.00	11,594,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,852,200.00	2,898,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	28,522,500.00	28,985,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	138,242,200.00	116,677,400.00
210301	Гэрэл, цахилгаан	49,584,861.17	44,561,489.90
210302	Түлш, халаалт	69,161,158.49	53,503,590.59
210303	Цэвэр, бохир ус	19,496,180.34	18,612,319.51
2104	Хангамж, бараа материалын зардал	24,885,800.00	30,465,780.05
210401	Бичиг хэрэг	4,026,460.00	4,213,461.00
210402	Тээвэр, шатахуун	4,198,750.00	4,204,996.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,822,943.00	11,566,091.63
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,319,850.00	5,876,576.76
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,517,797.00	4,604,654.66
2105	Нормативт зардал	67,626,900.00	66,126,900.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	495,000.00	1,495,000.00
210502	Хоол, хүнс	54,063,900.00	51,563,900.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	13,068,000.00	13,068,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	16,471,100.00	28,461,991.14
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	10,692,800.00	10,200,997.00
210604	Урсгал засвар	5,778,300.00	18,260,994.14
2107	Томиллолт, зочны зардал	3,155,600.00	3,155,600.00
210702	Дотоод албан томиллолт	3,155,600.00	3,155,600.00

**Барилгын политехникийн коллежийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	45,459,800.00	45,451,645.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	36,980,000.00	30,774,211.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	4,500,000.00	12,500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	495,000.00	495,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,386,000.00	330,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	118,800.00	118,800.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,980,000.00	1,233,634.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	166,960,275.00	180,145,656.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	166,960,275.00	180,145,656.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	217,270,507.80	142,376,196.81
2132	Бусад урсгал шилжүүлэг	211,570,298.00	124,627,474.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	114,026,300.00	62,678,770.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	53,744,000.00	61,948,704.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	43,799,998.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,700,209.80	17,748,722.81
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,700,209.80	17,748,722.81
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ -3=-1--2	<u>16,794,124.99</u>	<u>273,405,137.00</u>
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	=	=
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН -4	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН -5	16,794,125.00	273,405,937.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	16,794,125.00	273,405,937.00
2200	Дотоод эх үүсвэрээр	16,794,125.00	273,405,937.00
221001	Их засвар	-	197,540,848.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	16,794,125.00	75,865,089.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ -6=-4--5	<u>-16,794,125.00</u>	<u>-273,405,937.00</u>
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	=	=
14	Бусад эх үүсвэр	-	-
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	-	-
24	ГАДААД ЗЭЭЛИЙН ҮНДСЭН ТӨЛБӨР	-	-
25	Санхүүгийн үйл ажиллагааны зардал	-	-
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ -8=-3+-6+-7	-00.01	-800.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	20,000.01	21,000.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	20,000.00	20,200.00

## Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,631,698,814.29	380,960,888.05	-1,138,975,492.97	2,873,684,209.37
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	10,467,549.74	10,467,549.74
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,631,698,814.29	380,960,888.05	-1,129,713,663.93	2,882,946,038.41
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-10,939,549.74	-	-10,939,549.74
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	-248,026,674.90	-248,026,674.90
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,631,698,814.29	370,021,338.31	-1,376,534,618.13	2,625,185,534.47
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	940,278.10	940,278.10
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,631,698,814.29	370,021,338.31	-1,375,594,340.03	2,626,125,812.57
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	987,959,875.45	-	987,959,875.45
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	390,714,340.00			390,714,340.00
Тайлант үеийн үр дүн			304,509,401.31	304,509,401.31
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,022,413,154.29	1,357,981,213.7	-1,071,084,938.72	4,309,309,429.33

## Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

	/төгрөгөөр/			
Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,271,411,700.00	2,267,772,780.19	-3,638,919.81	99.8
УРСГАЛ ЗАРДАЛ	2,271,411,700.00	2,267,772,780.19	-3,638,919.81	99.8
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,143,148,100.00	2,143,145,306.19	-2,793.81	100.0
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,449,259,900.00	1,449,259,900.00	-	100.0
Үндсэн цалин	1,075,174,200.00	1,075,174,200.00	-	100.0
Нэмэгдэл	295,133,200.00	295,133,200.00	-	100.0
Унаа хоолны хөнгөлөлт	78,952,500.00	78,952,500.00	-	100.0
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	173,911,200.00	173,911,200.00	-	100.0
Тэтгэврийн даатгал	115,940,800.00	115,940,800.00	-	100.0
Тэтгэмжийн даатгал	14,492,700.00	14,492,700.00	-	100.0
ҮОМШӨ-ний даатгал	11,594,100.00	11,594,100.00	-	100.0
Ажилгүйдлийн даатгал	2,898,400.00	2,898,400.00	-	100.0
Эрүүл мэндийн даатгал	28,985,200.00	28,985,200.00	-	100.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	116,677,400.00	116,677,400.00	-	100.0
Гэрэл, цахилгаан	42,889,800.00	44,561,489.90	1,671,689.90	103.9
Түлш, халаалт	54,405,100.00	53,503,590.59	-901,509.41	98.3
Цэвэр, бохир ус	19,382,500.00	18,612,319.51	-770,180.49	96.0
Хангамж, бараа материалын зардал	30,225,800.00	30,225,780.05	-19.95	100.0
Бичиг хэрэг	4,207,500.00	4,213,461.00	5,961.00	100.1
Тээвэр, шатахуун	4,207,500.00	4,204,996.00	-2,504.00	99.9
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	10,044,100.00	11,326,091.63	1,281,991.63	112.8
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	7,980,000.00	5,876,576.76	-2,103,423.24	73.6
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,786,700.00	4,604,654.66	817,954.66	121.6
Нормативт зардал	66,126,900.00	66,126,900.00	-	100.0
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,495,000.00	1,495,000.00	-	100.0
Хоол, хүнс	51,563,900.00	51,563,900.00	-	100.0
Нормын хувцас, зөөлөн эдлэл	13,068,000.00	13,068,000.00	-	100.0
Эд хогшил, урсгал засварын зардал	40,673,100.00	40,672,676.14	-423.86	100.0
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	10,692,000.00	10,200,997.00	-491,003.00	95.4
Урсгал засвар	29,981,100.00	30,471,679.14	490,579.14	101.6
Томилолт, зочны зардал	3,155,600.00	3,155,600.00	-	100.0
Дотоод албан томилолт	3,155,600.00	3,155,600.00	-	100.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	79,423,800.00	79,421,450.00	-2,350.00	100.0
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	64,000,000.00	64,000,000.00	-	100.0

**Барилгын политехникийн коллежийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	12,500,000.00	12,500,000.00	-	100.0
Даатгалын үйлчилгээ	495,000.00	495,000.00	-	100.0
Тээврийн хэрэгслийн татвар	330,000.00	330,000.00	-	100.0
Тээврийн хэрэгслийн оношлогоо	118,800.00	118,800.00	-	100.0
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,980,000.00	1,977,650.00	-2,350.00	99.9
Бараа үйлчилгээний бусад зардал	183,694,400.00	183,694,400.00	-	100.0
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	183,694,400.00	183,694,400.00	-	100.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	128,263,600.00	124,627,474.00	-3,636,126.00	97.2
Бусад урсгал шилжүүлэг	128,263,600.00	124,627,474.00	-3,636,126.00	97.2
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	62,684,400.00	62,678,770.00	-5,630.00	100.0
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	65,579,200.00	61,948,704.00	-3,630,496.00	94.5
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>2,271,411,700.00</b>	<b>2,267,771,980.19</b>	<b>-3,639,719.81</b>	<b>99.8</b>
<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>2,076,701,700.00</b>	<b>2,064,875,625.19</b>	<b>-11,826,074.81</b>	<b>99.4</b>
Улсын төсвөөс санхүүжих	2,076,701,700.00	2,064,875,625.19	-11,826,074.81	99.4
<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>194,710,000.00</b>	<b>202,896,355.00</b>	<b>8,186,355.00</b>	<b>104.2</b>
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	148,460,000.00	109,952,020.00	-38,507,980.00	74.1
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	46,250,000.00	92,944,335.00	46,694,335.00	201.0
<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>146.00</b>	<b>146.00</b>	<b>-</b>	<b>100.0</b>
Удирдах ажилтан	3.00	3.00	-	100.0
Гүйцэтгэх ажилтан	118.00	118.00	-	100.0
Үйлчлэх ажилтан	25.00	25.00	-	100.0

## Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	32,000,855.00	32,000,855.00	-	100
УРСГАЛ ЗАРДАЛ	32,000,855.00	32,000,855.00	-	100
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	32,000,855.00	32,000,855.00	-	100
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	5,625,000.00	5,625,000.00	-	100
Үндсэн цалин	5,625,000.00	5,625,000.00	-	100
Хангамж, бараа материалын зардал	240,000.00	240,000.00	-	100
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	240,000.00	240,000.00	-	100
Эд хогшил, урсгал засварын зардал	12,141,815.00	12,141,815.00	-	100
Урсгал засвар	12,141,815.00	12,141,815.00	-	100
Бараа үйлчилгээний бусад зардал	13,994,040.00	13,994,040.00	-	100
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	13,994,040.00	13,994,040.00	-	100
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	197,540,848.00	197,540,848.00	-	100
Дотоод эх үүсвэрээр	197,540,848.00	197,540,848.00	-	100
Их засвар	197,540,848.00	197,540,848.00	-	100
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	229,544,351.00	229,541,703.00	-2,648.00	100
Улсын төсвөөс санхүүжих	197,540,848.00	197,540,848.00	-	100
Хөрөнгийн санхүүжилт	197,540,848.00	197,540,848.00	-	100
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	32,003,503.00	32,000,855.00	-2,648.00	100
Нэмэлт санхүүжилтийн орлого	32,003,503.00	32,000,855.00	-2,648.00	100
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	19,261,688.00	19,259,040.00	-2,648.00	100
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	12,741,815.00	12,741,815.00	-	100
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ - III=-II--I			-	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			-	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл			-	

## 5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2019.02.25	Аудитын нэр: 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан	Аудитын код: САГ-2019/27/СТА-ТШЗ
Шалгах байгууллагын нэр: Барилгын политехникийн коллеж		Төгрөгөөр

Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
		Нэр	Албан тушаал	Овог нэр
1	2	3	4	5
Дотуур байрны хүүхдийн хоолны төлбөр болох 220.3 мянган төгрөгийг хог хаягдлын зардлаас зарцуулсан байна.	220.30	Зөвлөмж өгөх	Захирал	Г.Нямдулам
Бараа бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээний дүнгээс 384.3 мянган төгрөгөөр илүү шууд худалдан авалт хийсэн.	384.20	Албан шаардлага өгөх	Захирал	Г.Нямдулам
Тайлант онд дотуур байр түрээслүүлсний 80,000.0 мянган төгрөгийн орлогын 30 хувь 24,000.0 төгрөгийг төсөвт төвлөрүүлээгүй байна.	24,000.00	Төлбөрийн акт тогтоох	Захирал	Г.Нямдулам
Хөдөлгүүрийн цилиндрийн багтаамж нь 2500 см3-ээс дээш, туулах чадвар өндөртэй 89,112.2 мянган төгрөгийн үлдэх өртөгтэй ланд-200 суудлын автомашиныг ашиглаж, 20,376.0 мянган төгрөгийн засварын зардал гаргаж, төсвийг үр ашиггүй зарцуулсан байна.	109,488.20	Албан шаардлага өгөх	Захирал	Г.Нямдулам
Түрээсийн орлогын төлбөр тооцоог сар бүр гэрээний дагуу бүртгэж тайлагнадаггүйгээс 11,305.0 мянган төгрөгийн орлогыг түрээслэгчтэй байгуулсан гэрээгүйгээр бүртгэсэн байна.	11,305.00	Албан шаардлага өгөх	Захирал	Г.Нямдулам
Авлагын үлдэгдэл 42,645.4 мянган төгрөг буюу оны эхнээс 13,290.1 мянган төгрөгөөр, өр төлбөр 39,672.2 мянган төгрөг буюу оны эхнээс 950.7 мянган төгрөгөөр тус тус өссөн байна.	14,240.70	Зөвлөмж өгөх	Захирал	Г.Нямдулам

Барилгын политехникийн коллежийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн 2018 оны 06/18 дугаартай дүгнэлтээр 42 нэр төрлийн 13,783.6 мянган төгрөгийн бараа материалыг бүртгэлээс хасах шийдвэр гаргасан боловч борлуулах, устгах тухай заагаагүй байна.	13,783.60	Зөвлөмж өгөх	Захирал	Г.Нямдулам
Нийт 1,002.4 мянган төгрөгийн бараа материалыг захиалгын хуудсаар олгохдоо гарын үсгээр баталгаажуулаагүй байна.	1,002.40	Зөвлөмж өгөх	Захирал	Г.Нямдулам
Тайлант хугацаанд нийт 74 удаагийн 15,841.9 мянган төгрөгийн бараа материалыг орлогод бүртгэхдээ И баримтыг хавсаргаагүй байна.	15,841.90	Албан шаардлага өгөх	Захирал	Г.Нямдулам
2018 оны жилийн эцэст хөрөнгийн тооллого хийсэн боловч тооцоог бодоогүй байна.	-	Албан шаардлага өгөх	Захирал	Г.Нямдулам
Цалин хөлсөнд илүү олгосон 24,001.0 мянган төгрөг, дутуу олгосон 4,486.4 мянган төгрөг нийт 28,487.4 мянган төгрөгийг цалингийн цэсэнд сөрөг утгатайгаар бүртгэсэн байна..	28,487.40	Зөвлөмж өгөх	Захирал	Г.Нямдулам





